*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

# ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРЫН БЭЛЧЭЭР, ГАЗАР ТАРИАЛАНГИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН СУНДУЙ ОВОГТОЙ МӨНХСОЁЛЫН 2024 ОНЫ БҮТЭН ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | *НЭГ: "Албан тушаалын зорилго зорилт, чиг үүргийн арга хэмжээний " ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД"* | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. Бэлчээр газар тариалангийн чиглэлээр гарсан хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулах, норм нормативыг сурталчлах, хэрэгжилтыг зохион байгуулах | Хууль тогтоомж, стандарт, бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ авсан тоо | Хууль тогтоомж, стандарт, бодлогыг хэрэгжүүлэх | 2 | Газар тариалангийн үйл ажиллгаа эрхэлдэг иргэн, аж ахуй нэгжүүдэд бэлчээр газар тариалангийн чиглэлээр гарсан хууль тогтоомж, стандартын хэрэгжилт, норм нормативыг сурталчлах, хэрэгжилтыг зохион байгуулж ажилласан | 2024-01-01 2024-12-20 | 100 |
| 2. | Арга хэмжээ 1.2. Тариалалтын болон ургац хураалтын мэдээг тогтоосон хугацаанд холбогдох байгууллагуудад мэдээлэх | Тогтоосон хугацаанд тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна | Мэдээ тайлан хүргэгдсэн байна | - | Хаврын тариалалт, намрын ургац хураалтын мэдээ тайланг 7 хоног бүрийн 1, 4 дэхь, хобогдох судалгааг тухай бүр Сумын засаг даргад танилцуулж, Аймгийн Засаг даргын дэргэдэх ХХААГазар, ХХААХҮЯаманд хүргүүлсэн | 2024-01-01 2024-12-20 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | Арга хэмжээ 1.3. Бэлчээрийн хөнөөлт мэрэгч үлийн цагаан оготнотой микробиологийн болон энгийн механик биологийн аргаар тэмцэх арга хэмжээг зохион байгуулах | Мэрэгч усгалын ажил зохион байгуулсан бэлчээр га-гаар | 12000 га | 12000 | 2024 онд Хархорин сумын Засаг даргын "Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх ажлыг зохион байгуулах тухай" захирамжаар Орон нутгийн хөгжлийн сангийн 75,5 сая төгрөг, Улсын төсвийн 100,7 сая нийт 176,2 сая төгрөгийн санхүүжилтээр сумын Нарийн хүр багийн Шар бондгор, Талын дөрвөлжин, Зүүн намаг, Онгоцон ухаа багийн Хөгшин гол дагуу, Цагаан нуур, Наадмын дэнж, Азарын дэрс, Туркийн замын хойд урд тал, Урт богино хамар, Дөрвөлжин, Мөрөгцөг, Улаан худаг, Худаг элстий, Ар элстий, Жалбаа багийн Овоот, Тасархай,Тариат, Булашт, Өвөр хадат, Дэл, Сарын гол, Ар хадат, Цагаан нуур, Өвөр элстий, Шанх багийн Шар_бүрд, Хүрэн ширэх, Бумбат, Дэрсэн худаг орчмын 17,5 мянган га бэлчээрийг 2024 оны 04 дүгээр сарын 04 -ны өдрөөс эхлэн 7 хоногийн хугацаанд микробиологийн аргаар хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх ажил зохион байгуулж 85,6 хувийн үр дүнтэй хүлээлгэн өгсөн. Мөн Улсын төсвийн 9,2 сая төгрөгийн хөрөнгөөр 6668 га талбайд энгийн механик аргаар бэлчээрийн хөнөөл мэрэгч амьтантай тэмцэх ажлыг 78 хувийн үр дүнтэй хийж гүйцэтгэсэж тус онд нийт 185,4 сая төгрөгийн санхүүжилтээр 24,2 мянган га талбайд мэрэгч устгалын ажил зохион байгууллаа. | 2024-04-04<br>2024-04-20 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4. | Арга хэмжээ 1.4.<br>Усалгаатай газар тариалангийн хэмжээг нэмэгдүүлэх, таримлын зохистой сэлгээ хийж, нэгжээс авах ургацыг нэмэгдүүлсэн байна. | Усалгаатай талбайн нэмэгдсэн хэмжээ | 1.1000 га | 5 | Суманд тус онд 8 аж ахуй нэгж, 185 өрх 235 га талбайд төмс хүнсний ногоо тариаллаа. Хархорин ХК ны услалтын суваг эвдэрч ногооны талбайруу ус хүрэлцэхгүй байсныг тус компантай зөвшилцөж услалтын сувгыг засварлаж ус түр урсгаж, ногоочид гадаргын усаар хангагдсан.<br>Сумын төмс хүнсний ногоо тариалах байршил шинэ Хархорум хотын төлөвлөлтөд орсон тул 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд шинээр газар эзэмшүүлэх байршил ороогүй. | 2024-04-01<br>2024-06-20 | 100 |
| 5. | Арга хэмжээ 1.5.<br>Газар тариалангийн эргэлтийн талбайн ашиглалтыг нэмэгдүүлж, тариаланчдыг бордоо, болон техникийн, хүнсний ногооны тариалан эрхлэгчдийг үрийн дэмжлэгт тус тус хамруулах | 1.Эргэлтийн талбайн нэмэгдсэн хэмжээ,<br>2. Дэмжлэг үзүүлсэн аж ахуй нэгж иргэний тоо | 11,000 га<br>100 ААН, иргэн | 100<br>50 | Тус онд 6520 га талбайд 3 төрлийн үр тарианы ургамал, 5200 га талбайд тосны ургамал, 2960 га талбайд тэжээлийн ургамал, 237 га талбайд төмс хүнсний ногоо нийт 114811 га талбайд тарилалт хийгдээд байна. Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 21/03 дугаар Сумын 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт оруулах тухай тогтоолоор 127,6 га талбайг хоршоодод эзэмшүүлэхээр тогтоож 6 хоршоонд 30 га талбай олгосон. Мөн Шанх, Жалбаа баг шинээр 120 га талбайг малчдад тэжээлийн ургамал тариалах зориулалтаар олгож нийт 150 га-аар эргэлтийн талбайг нэмэгдүүлсэн. Суманд тус онд 8 аж ахуй нэгж, 185 өрх 237 га талбайд төмс хүнсний ногоо тариаллаа. Тариалалтыг дэмжих зорилгоор | 2024-04-04<br>2024-12-11 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ХХААХҮЯамнаас төмс хүнсний ногооны тариалан эрхлэгчдэд 80 хувийн хөнгөлөлттэй үрийн дэмжэг үзүүлсэн. Манай сумаас ХХААГазраар дамжуулан 4 аж ахуй нэгж, 92 тариаланч 2,8 тн үр захиалж үрийн дэмжлэгт хамрагдсан. | | |
| 6. | Арга хэмжээ 1.6. Тариалангийн талбайд мал, тэжээвэр амьтан орсны улмаас тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажилласан байх. | 1. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах. | Гүйцэтгэл хувь | 100% | Мөн БОХУБайцаагч, тариалангийн бүс нутаг бүхий багийн Засаг даргатай хамтран тариалангийн бүс нутаг, тариалангийн талбайн ойр шахан буусан 47 малчин өрхөд албан мэдэгдэл хүргүүлж "Тариалангийн тухай хууль, Газрын тухай хууль, "Бэлчээр ашиглалтын журам"-ыг танилцуулж ажилалаа. | 2024-04-04<br>2024-11-01 | 100 |
| 7. | Арга хэмжээ 1.7. Дараа онд тариалах талбайн 90-ээс багагүй хувьд хүрэлцэхүйц хэмжээний чанар сайтай сортын үрийн нөөцийг намрын ургацаас бүрдүүлэх | Бүрдүүлсэн үрийн нөөцийн хэмжээ | 1000 тн | - | Намрын ургацаас дараа онд тариалах 1100 тн үрийг нөөцөлсөн. Мөн борлуулалтын шатанд 2000 тн үр бултгэгдээд байна. | 2024-09-01<br>2024-12-20 | 100 |
| ХОЁР.. Газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, усалгаатай тариалан эрхлэх үйл ажиллагааг дэмжих ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 2.1. Сумдад агро-ойн аж ахуй байгуулах, жимс жимсгэний тариалалтыг нэмэгдүүлэхэд газар, хөрөнгө, санхүүгийн дэмжлэг үзүүлэх | Агро-ойн аж ахуйн тоогоор | Ойн аж ахуйн чиглэлээр 4 аж ахуй нэгж ажиллаж байна | 1 | Тус онд 3 аж ахуй нэгж 2 иргэн 2 га талбайд 2000 ширхэг /улиас, хайлаас/ ойн зурвас шинээр байгуулсан. Суманд агро ойн аж хүйн чиглэлээр 3 аж ахуй нэгж 2 иргэн үйл ажиллагаа явуулж байна. Сумын газар тариалангийн зориулалтаар газар олгох байршил Шинэ Хархорум хотын суурьшилын бүсийн төлөвлөлтөд орсон тул 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд шинээр газар эзэмшүүлэх байршил ороогүй. Тус онд 3 аж ахуй нэгж 2 иргэн 2 га талбайд 2000 | 2024-04-04<br>2024-12-20 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ширхэг /улиас, хайлаас/ ойн зурвас шинээр байгуулсан. Мөн Эрдэнэсийн хотхон ХХК нь Оросын холбооны улсаас 2000 ширхэг олон төрлийн жимсний суулгац авчирч агро ойн аж ахуй, жимсний аж ахуй байгуулхаар эхлэл тавигдлаа. | | |
| 2 | Арга хэмжээ 2.2. Сумдад өвөл, зуны хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх, газар олгох, хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг үзүүлж, зорилтот жилийн хүрээнд олгосон хүлэмжийн ашиглалтыг сайжруулж ажиллах. | Шинээр нэмэгдсэн хүлэмжийн талбайн хэмжээгээр<br>Хүлэмжийн тоо | Суманд 130 хүлэмж ашиглагдаж байна | 2 | Тус онд 64 м2 зуны 800 м2 өвлийн хүлэмж ашиглалтад орлоо. Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх зорилтот жилийн хүрээнд олгогдсон 32 м.кв 2 хүлэмжийг 2024 оны Зорилтот жилийн хүрээнд зарлагдсан уралдаанд тэргүүлсэн 2 иргэнд ашиглалтын гэрээгээр эзэмшүүлж, барьж байгуулан тариалат хийгдэж ургацын хэмжээг нэмэгдүүлсэн. Мөн суманд “Мойлт ундарга” ХХК нь 200 сая төгрөгийн санхүүжилтээр 800 м.кв өвлийн хүлэмж “Бат хүлэмж” ХХК-аар бариулж ашиглалтад оруулж тариалалт хийгдсэн. Шинээр 2 иргэн 64 м2 хүлэмж барьж ашиглалтад оруулаа | 2025-01-05<br>2025-06-09 | 100 |
| 3 | Арга хэмжээ 2.3. Тариалалт, уринш боловсруулалт, ургац хураалтыг технологийн хугацаанд гүйцэтгэх техникийн хангамж, шатах тослох материалын нөөц бүрдүүлэх, ургацыг хамгаалах, ургацын зам засвар зэрэг ажлуудыг гүйцэтгэхэд шаардлагатай арга хэмжээг зохион байгуулах | Хэрэгжилтийг хугацаанд нь тухай бүр авч ажилласан байх (хувь) | Хэрэгжилт 100 хувь | 100% | Тус онд 6520 га талбайд 3 төрлийн үр тарианы ургамал, 5200 га талбайд тосны ургамал, 2960 га талбайд тэжээлийн ургамал, 237 га талбайд төмс хүнсний ногоо нийт 14,8 мянган га талбайд тариалалт хийж, 5000 га талбайд уриншийн боловсруулалт хийлээ. Дотоодын хэрэгцээний үр тариа 6790 га талбайд тариалж, 840 га талбай мөндөрт нэрвэгдэж, 50 га талбай тэжээлд шилжиж 5900 гагаас 4660 тн ургац хураан авч, 50 хувь, төмс 122 га талбайгаас 1098 тн ургац | 2024-04-04<br>2024-12-11 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хураан авч 100 хувь, хүнсний ногоо 115 га талбайгаас 1092,5 тн хураан авч 60 хувь тус тус хангалаа. Хаврын тариалалт намрын ургац хураалтад 280 хү ажилалаа. | | |
| 4 | Арга хэмжээ 2.4. Тариалангийн талбайд ойн зурвас байгуулах | Ойн зурвас байгуулсан талбайн хэмжээ га-аар | Сумын хэмжээнд 60 га талбайд ойн зурвас байгуулсан. | 4 | Тус онд 3 аж ахуй нэгж 2 иргэн 2 га талбайд 2000 ширхэг /улиас, хайлаас/ ойн зурвас шинээр байгуулсан. Мөн Эрдэнэсийн хотхон ХХК нь Оросын холбооны улсаас 2000 ширхэг олон төрлийн жимсний суулгац авчирч агро ойн аж ахуй, жимсний аж ахуй байгуулах эхлэл тавигдлаа. | 2024-04-04 2024-11-20 | 100 |
| 5 | Арга хэмжээ 2.5. Хүнсний ногооны төрөлжсөн зоорь /автомажсан, механикжсан/ -ийн аж ахуйг хөгжүүлэх, дэмжлэг үзүүлэх | 1. Шинээр барьж байгуулсан зоорын тоогоор | Сумын хэмжээнд 770 тн багтаамжтай 43 зоорь ашиглагдаж байна | 1 | Тус онд суманд 1 зоорь барьж, 2 зоорь их засварын ажил хийхээр төлөвлөж байна | 2024-07-20 2024-09-20 | 100 |
| 6 | Арга хэмжээ 2.6. Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 3.3.2 дахь заалт “Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийн механикжуулалтыг сайжруулах, техник, технологийн шинэчлэл хийх зорилгоор тухайн жилд худалдан авсан техникт 50 хувийн хөнгөлөлт үзүүлэх” арга хэмжээг хэрэгжүүлэх | 1. Худалдан авсан техникийн тоо | 2 | 1 | Тогтоолын хэрэгжилтийг суманд газар тариалангийн үйл ажиллагаа явуулдаг иргэн, аж ахуй нэгжүүдэд танилцуулж 50 хувийн хөнгөлөлтөд хамрагдах боломжтой ХХААХҮЯамтай гэрээтэй аж ахуй нэгжүүдыг жагсаалтаар хүргүүлсэн. Хөнгөлөлтэд хамрагдахаар 2 аж ахуй нэгж хүсэлт ирүүлсэнч ХХААХҮЯамтай гэрээтэй аж ахуй нэгжүүд дээр байгаа техник зах зээлийн үнээс илүү үнтэй байна гэсэн шалтгаанаар техник худалдан авахаас татгалзсан | 2024-01-01 2024-06-20 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7. | Арга хэмжээ 2.7.<br>Өвөлжөө, хаваржааны 0.7 га газрын дэргэд 1000 м.кв-газарт малын тэжээлийн ургамал тариалах, багийн тэжээлийн талбайд тэжээл тариалах | Тэжээлийн ургамал тариалсан өрхийн тоогоор | 200 өрх тариалдаг | 250 | ХХААГазраас өвөлжөө бууцныхаа хөлд тэжээлийн ургамал тариалах зориулалтаар хямдралтай үнээр тэжээлийн үр олгохоор судалгааг хүргүүлээд байна. Судалгаанд сумаас 80 өрх хамрагдлаа. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хөдөөгийн 5 багт тэжээлийн ургамал тариалах зориулалтаар 60,0 сая төгрөгийн санхүүжилт олгож төрийн худалдан авах ажиллагааны дагуу тендер зарлаж 47 тн тэжээлийн үр худалдан аваад байна. Хөдөөгийн 5 баг нийт 365 га талбайд 417 өрх тариалалт хийж малчид га тутмаас 2,5-3 тн ногоон тэжээл хураан авсан | 2024-04-01<br>2024-07-01 | 100 |
| 8. | Арга хэмжээ 2.8.<br>Тэжээлийн ургамал тариалалтыг нэмэгдүүлэх, дэмжлэг үзүүлэх | Тариалсан талбай га аж ахуй нэгж иргэний тоо | 2000 га талбайд тариалдаг | 2500 | 2024 онд 12 аж ахуй нэгж, 25 иргэн, 417 малчин нийт 2730 га талбайд тэжээлийн ургамал тариалж 4440 тн ургац хураан авлаа. ОНХСангийн хөрөнгөөр малдад тариалах үр, хашааг худалдан авч олгосон. Мөн малчдад үрийн дэмжлэг үзүүлж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу тендер сонгон шалгаруулалт зарлаж, "Бат ундарга" ХЭТ ХХК тендер шалгарч үр нийлүүлсэн. Нийт 60,0 сая төгрөгөөр 47,8 тн тэжээлийн үр /буудай-22тн, овъёос-25,8 тн/ худалдан авч багийн малчдаас ирүүлсэн захиалгын дагуу хөдөөгийн 5 багт хуваарилан олгосон. Тус онд шинээр атаршсан 100 га талбайг эргэлтэд орууллаа. Тус онд ОНХСангийн санал асуулгаар гүн өрмийн худаг гаргуулах санал орж ирээгүй. Сумын аюулгүй нөөцөд 50 тн (2000 боодол) ногоон тэжээл | 2024-05-20<br>2024-11-20 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | худалдан авах зар хүргэсэн нийлүүлэгч орж ирээгүй. 17 сая төгрөгийг нөөцийн санд төвлөрүүлээд байна. | | |
| 9 | Арга хэмжээ 2.9. Статистикийн мэдээ тайланг хугацаанд нь гаргаж, иргэд, төрийн байгууллага, албан тушаалтанг тухай бүрт нь хангаж ажиллах | Хугацаанд нь тайлагнасан эсэх | Хугацаанд нь гаргаж хуваарийн дагуу хүргүүлсэн байна. | 100 % | Хүн, ам өрхийн мэдээллийн санд багийн Засаг дарга, багийн зохион байгуулагчтай хамтран сум, багийн хүн ам, өрхийн мэдээллийн сангийн өрх, хүн амын үзүүлэлтэд тухай бүр үнэн зөв хөтөлж, тогтмол баяжилт хийж ажиллаж байна. Аймгийн Статистикийн хэлтсийн даргын 2024 оны А/01 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтын дагуу анхан шатнаас цуглуулах статистик мэдээ, тайланг Статистикийн хуулийн дагуу сар бүрийн болон улиралын статистик мэдээ тайлан ( ХАА1-8, СХ, АҮ, ТББ, МЭ, ЗГ, Т, ББО, А-ОС3, А-ОС4, ХҮИ, ) -г иргэн аж ахуй нэгж бүрээр цуглуулан програмд шивж, Статистикийн хэлтэст хүргүүлсэн. Хагас жилийн малын түүвэр судалгааг зохион багуулж шивж оруулсан. 2024 оны мал тэжээвэр амьтан хашаа худгийн тооллогийг 13 хэсэг 48 албан хаагч ажиллаж амжилттай зохион байгууллаа. Хүн, ам өрхийн мэдээллийн санд багийн Засаг дарга, багийн зохион байгуулагчтай хамтран сум, багийн хүн ам, өрхийн мэдээллийн сангийн өрх, хүн амын үзүүлэлтэд тухай бүр үнэн зөв хөтөлж, тогтмол баяжилт хийж ажиллаж байна | 2024-01-01 2024-12-25 | 100 |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.<br>Сумын аюулгүй нөөцийн өвс тэжээл бүрдүүлэх | Нөөц бүрдүүлсэн байх | 50 тн өвс<br>15 тн тэжээл | 50 тн өвс<br>15 тн тэжээл | Тус онд сумын аюулгүй нөөцөд 2000 боодол буюу 50 тн ногоон тэжээлийн нөөц бүрдүүлж малчдад олгосон. Мөн хямдралтай үнээр улсын нөөцийн Хархорин салбараас 1600 шуудай буюу 40 тн хивэг хямдралтай үнээр, 1200 шуудай буюу 30 тн хивэг үнэгүй, 21,5 тн тэжээлийн будаа татан төвлөрүүлж 1219 малтай өрхөд олгосон. Мөн 19,8 сая төгрөгийг нөөцийн санд төвлөрүүлээд байна. Цаашид өвс тэжээлийн нөөц бүрдүүлэхээр судалгаа хийж байна. | 2024-01-01<br>2024-12-20 | 100 |
| 2. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2.<br>Төрийн худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд ажилласан | Томилогдсон | 4 | 4 | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах ажиллагаанд 6 тендерийн үнэлгээний хороонд ажиллсан. | 2024-01-01<br>2024-12-11 | 100 |
| 3. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3.<br>Цахим шилжилт зорилтот жил, Шинэ хоршоо хөдөлгөөн, Сумын онцгой комиссын ажлын хэсэгт ажиллаж арга хэмжээ зохион байгуулсан | Томилогдсон | 2 | 2 | Цахим шилжилт зорилтот жил, Шинэ хоршоо хөдөлгөөний ажлын хэсэгт ажиллаж 2 удаагын арга хэмжээ зохион байгуулсан | 2024-01-01<br>2024-12-11 | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1.1.<br>Үйл ажиллагаандаа ашиглаж байгаа хууль тогтоомжуудыг | 1.Хамрагдсан болон бие | 1.1.5-аас доошгүй хууль тогтоомж, | 2 | Тариалангийн тухай хууль, Газрын тухай хууль, Статистикийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны нууцын тухай хууль, Төрийн худалдан | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | судлан хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх. | даан судалсан сургалтын тоогоор | журмыг судалсан. | | авах ажиллагаа, бусад хууль нэмэлт өөрчлөлтийг хууль тогтоомжуудыг судлан хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлсэн | 2024-01-01<br>2024-12-11 | 100 |
| 2. | Арга хэмжээ 1.2.<br>Төрийн албаны зөвлөлийн сайт дээр байршуулсан сургалтын материалуудыг судалж, мэдлэг мэргэшлээ дээшлүүлэх | Сургалтад идэвхитэй хамрагдсан байна | 6 | 3 | Төрийн албаны зөвлөлийн сайт дээр байршуулсан сургалтын материалуудыг судалж, мэдлэг мэргэшлээ дээшлүүлсэн. Танхимаар 3, онлайнаар 6 удаагын сургалтад хамрагдсан | 2024-01-01<br>2024-12-11 | 100 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

БЭЛЧЭЭР, ГАЗАР ТАРИАЛАНГИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ............................... ( С.МӨНХСОЁЛ ) 2024 он..... сар.... өдөр

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*